

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 дугаар тушаалын
6 дугаар хавсралт

ЭРХ ЗҮЙН АСУУДАЛ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН ДУГАРСҮРЭНГИЙН ГАНТУЯАГИЙН
2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур ҮЗҮҮЛЭЛТ	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэл тийн хувь
1	2	3	4	5	6	7	
Зорилт 1. “ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН БОДЛОГО, ХУУЛЬ ТОГТООМЖИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД”							
1.	Арга хэмжээ 1.1. Эрүүл мэндийн салбарын багц хуулийн өөрчлөлт, шинэчилсэн найруулгад санал хүргүүлнэ.	Хүргүүлсэн саналын тоо	Ахмад настны тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд санал хүргүүлсэн.	Салбарын багц хууль тогтоомжийн өөрчлөлт, шинэчилсэн найруулгад судалгаа хийсэн байна.	Эрүүл мэндийн салбарын 33 хуульд дүн шинжилгээ хийж, Донорын тухай хууль, Эрхтэн эд эс шилжүүлэн суулгах тухай хуулийн 2 төсөлд санал хүргүүллээ. <i>Үр дүн:</i> Холбогдох газарт ЭМДЕГ-ын санал хүргэгдсэн.	2025.01.02 2025.05.25	100
2.	Арга хэмжээ 1.2. Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн шинэчилсэн найруулга хийх ЭМЯ-ны ажлын хэсэгтэй хамтран ажиллаж, хүргүүлнэ.	Хүргүүлсэн саналын тоо	ЭМДтХ-ийн шинэчлэн найруулсан төсөлд 22 хүргүүлсэн.	ЭМДЕГ-ын даргын тушаалаар ажлын хэсэг байгуулан ажиллуулж, байгууллагын төв, орон нутгийн газар, хэлтсээс санал авсан байна.	Тайлант хугацаанд Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн зүйл, заалт бүрийг судлаад өөрчлөн найруулах 7, нэмж оруулах 10, хасах 7 нийт 24 санал боловсруулсан. ЭМДЕГ-ын даргын 2025 оны А/08 дугаар тушаалаар ажлын хэсгийг байгуулж, салбарын хуульд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж ажиллалаа.	2025.01.02 2025.05.25	100

					Үр дүн: Саналыг боловсруулж ажлын хэсэгт хүргүүлэхэд бэлэн болсон.		
3.	Арга хэмжээ 1.3. Эрүүл мэндийн даатгалын байгууллагын хууль эрх зүйн орчинд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, зөрчил, хийдлийг арилгана.	Хяналт шинжилгээний дүн	Шинээр болон шинэчлэн 18 журам, 4 аргачлал, 2 дүрмийг батлан мөрдөн ажиллаж байна.	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын дотоодод мөрдөгдөх дүрэм, журмыг судлах ажлын хэсэг байгуулсан байна.	Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд хяналт, шинжилгээ үнэлгээ хийж батлагдвал зохих 14 журам, 2 дүрэм, 1 төсөв батлахаар хуульчилсан боловч 2 журам батлагдаагүй байна. Эрүүл мэндийн даатгалын тухай хуулиар ЭМДБ-ын хулээсэн чиг үүргийн хэрэгжилтийн хувь 96.3 хувь, огт хэрэгждэггүй 3 зүйл, 3 заалт байна. Үр дүн: ЭМДтХуулийн зүйл заалтад дүн шинжилгээ хийж, хуульд нийцүүлсэн байна.	2025.01.02 2025.05.25	100
4.	Арга хэмжээ 1.4. Агентлагийн даргын тушаал, холбогдох бусад шийдвэрийн төслийг эрх зүйн талаас хянаж зөвлөгөө өгнө.	Тайлант хугацаанд хянасан тушаал, шийдвэрийн нийт тоо	Агентлагийн даргын тушаалын төслийн хууль эрх зүйн үндэслэлийг хянасан 64 тушаал, 4 тушаалын төсөлд санал авч боловсруулсан байна.	Тайлант хугацаанд тушаал, шийдвэрийн эрх зүйн үндэслэлийг хянасан байна.	Тайлант хугацаанд ЭМДЕГ-ын даргын 5 тушаал, Эрүүл мэндийн яам, Хууль зүй, дотоод хэргийн яаманд тус тус 1, Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлд 1, Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газарт 1, иргэний өргөдөл гомдол шийдвэрлэсэн 3 албан бичгийг тус тус боловсруулан хүргүүлсэн байна. Үр дүн: ЭМДЕГ-ын даргын 5 тушаал, холбогдох салбар байгууллага, иргэний өргөдөл гомдол шийдвэрлэсэн 8 албан бичгийг хянаж хүргүүлсэн байна.	2025.01.02 2025.05.25	100

5.	Арга хэмжээ 1.5. Эрүүл мэндийн даатгалын үйл ажиллагаанд хэрэглэгдэж буй гэрээний бүртгэл хөтлөх, шинээр болон шинэчлэн боловсруулахад санал, зөвлөмж өгөх, шаардлагатай тохиолдолд хамтран ажиллах, эрх зүйн үндэслэлийг хуульд нийцүүлэн хянах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.	Гэрээний тоо, хуулийн үндэслэл	233 гэрээ байгуулж ажилласан.	Гэрээний эрх зүйн үндэслэлийг хуульд нийцүүлэн хянаж, бүртгэл хөтөлсөн байна.	2025 оны хагас жилийн байдлаар Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газартай байгуулах Хамтран ажиллах тухай шинэчлэн боловсруулж буй гэрээний төсөлд санал өгч хууль эрх зүйн зөвлөгөө мэдээллээр хангаж, Бодлого төлөвлөлтийн газарт санал хүргүүлэн ажилласан. Байгууллагын хэмжээнд нийт хамтран ажиллах гэрээ 56, ажил гүйцэтгэх гэрээ 23, худалдах, худалдан авах гэрээ 1, хөлсөөр ажиллах гэрээ 2, үл хөдлөх хөрөнгө худалдан борлуулах зуучлалын гэрээ 1, ажлын байр түрээслэх гэрээ 1, нийт 84 гэрээнд эрх зүйн үндэслэлийг хуульд нийцүүлэн хянаж, санал, зөвлөмж өгч гэрээний хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна. <i>Үр дүн:</i> Шинэчлэн боловсруулсан 1 гэрээний төсөлд санал хүргүүлсэн. Гэрээний эрх зүйн үндэслэлийг 84 удаа хуульд нийцүүлэн хөтлөх үйл ажиллагааг хэрэгжүүлж байна.	2025.01.02 2025.05.25	100
6.	Арга хэмжээ №1.6 Захиргааны ерөнхий хуульд заасны дагуу сонсох ажиллагааг явуулах, тайлбар, нотлох баримт цуглуулах, дүгнэлт бичин шийдвэрлүүлнэ.	Сонсох ажиллагааны тоо	22 сонсох ажиллагаа явуулж, 6 албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулсан байна.	Сонсох ажиллагааг хуулийн хүрээнд явуулж шийдвэрлэсэн байна.	Захиргааны ерөнхий хуульд заасны дагуу албан хаагчид сонсох ажиллагааг явуулах, тайлбар, нотлох баримт цуглуулах ажиллагаа хийгдээгүй байна. <i>Үр дүн:</i> Удирдлагаас үүрэг даалгавар өгөгдөөгүй тул	2025.01.02 2025.05.25	-

					сонсох ажиллагаа хийгдээгүй байна.			
7.	Арга хэмжээ №1.7 Шүүх, хууль хяналтын байгууллагад байгууллага, албан тушаалтныг төлөөлөх, мэдээлэл, нотлох баримт бүрдүүлэх, тайлбар гаргах, хамтран ажиллах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.	Тайлант хугацаанд хамтран ажилласан тохиолдлын тоо	1044	хэрэгт төлөөлөн оролцсон.	Байгууллага, албан тушаалтныг төлөөлөн оролцож, хамтран ажилласан байна.	Нийслэл, дүүргийн Цагдаагийн байгууллагад хянагдаж буй 458 эрүүгийн хэрэгт иргэний нэхэмжлэгчээр , Шүүхийн байгууллагад иргэний хэргийн хариуцагчаар 3, нэхэмжлэгчээр 2, захиргааны шүүхэд хариуцагчаар 1 хэрэгт тус тус төлөөлөн оролцож нийт 464 хэрэгт тайлбар мэдүүлэг өгч, холбогдох нотлох баримтыг гаргаж өгсөн байна. Шүүхээс Сүвэн-Уул ХХК-ийн нэхэмжилсэн 174,740,000 төгрөг, Аюурвэйд ХХК-ийн нэхэмжилсэн 187,480,000 төгрөгийг хэрэгсэхгүй болгон шийдвэрлэж, ЭМД-ын санд учирсан гэм хорын хохирол болох 8,253,900 төгрөгийг хариуцагч ЭМДСанд нэхэн төлүүлэхээр шийдвэрүүд тус тус гарсан. <i>Үр дүн:</i> Хууль хяналтын байгууллагатай 464 удаа байгууллагаа төлөөлөн оролцож, Шүүхийн байгууллагад 11, Прокурорын байгууллагад 22, Цагдаагийн байгууллагад 6 удаа хүсэлт, нотлох баримт, итгэмжлэл олгосон албан бичиг боловсруулж хүргүүлсэн байна.	2025.01.02 2025.05.25	100
8	Арга хэмжээ №1.8 Эрүүл мэндийн даатгалын ерөнхий	Эрх зүйн туслалцаа	Тайлант хугацаанд 225 албан хаагчид хууль эрх зүйн	Хууль зүйн зөвлөгөө, мэдээлэл, мэргэжил арга зүйн	Тайлант хугацаанд ЭМДтХуулийн 12.1.1-т заасны дагуу төв, орон нутгийн 160			

	газрын төв, орон нутгийн ажилтнуудыг хууль зүйн мэдээлэл, зөвлөгөө, эрх зүйн туслалцаа үзүүлнэ.	үзүүлсэн албан хаагчдын тоо	мэдээлэл, зөвлөгөөгөөр ханган ажилласан.	удирдлагаар хангаж, эрх зүйн туслалцаа үзүүлж ажилласан байна.	албан хаагчдад цахим уулзалт зохион байгуулж хууль эрх зүйн зөвлөгөө мэдээлэл өглөө. <i>Үр дүн:</i> 160 албан хаагчдад хууль эрх зүйн мэдээлэл, зөвлөгөө өгсөн.		
--	---	-----------------------------	--	--	--	--	--

Зорилт 2. “ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО БҮРДҮҮЛЭХ” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД.”

1.	Арга хэмжээ 2.1. Чингис хаан банк ХХК, “Үндэсний хөрөнгө оруулалтын банк” ХХК-нд холбогдох мөнгөн авлага барагдуулах ажлыг эрчимжүүлж, цаашид авах арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлнэ.	Хүргүүлсэн албан бичгийн тоо	Төлбөр барагдуулах талаар 8 албан бичгийг хүргүүлсэн байна.	ЭМДЕГ, НДЕГ, Хөгжлийн банктай хамтарсан ажлын хэсэг байгуулж, үр дүнг тооцсон байна.	Чингис хаан банк ХХК, ҮХОБ-нд холбогдох авлага барагдуулах ажлын хэсгийн төлөвлөгөө батлуулж, төлөвлөгөөний дагуу ШШГГ-ын ахлах шийдвэр гүйцэтгэгч, Чингис хаан банк ХХК, ҮХОБ-ны шийдвэр гүйцэтгэгч нартай хамтарсан уулзалт зохион байгуулж ажиллалаа. Түүнчлэн ШШГЕГ-тай банкны өр барагдуулах чиглэлээр хамтарсан санамж бичгийг байгуулж, үйл ажиллагааг эрчимжүүллээ. Мөн өр барагдуулалтын байдал, цаашид авах арга хэмжээний талаар Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн хуралдаанд тусгайлан асуудал боловсруулан танилцуулж, тодорхой асуудлаар чиглэл авсан. Тайлант хугацаанд нийт 30.8 тэрбум төгрөгөөс 935,280,898 төгрөг барагдуулаад байна. <i>Үр дүн:</i> ШШГГ-т хандаж өр төлбөр барагдуулах талаар 5 албан бичиг хүргүүлэн, Банкны өр барагдуулах үйл ажиллагааг эрчимжүүлж, ЭМД	2025.01.02 2025.05.25	100
----	--	------------------------------	---	--	--	--------------------------	-----

				сангийн мөнгөн хөрөнгийг нөхөн бурдуулж байна.			
2.	Арга хэмжээ 2.2. Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийн 12.1.1 дэх заалтад “гэмт хэрэг, зөрчлийн улмаас эрүүл мэнд нь хохирсон даатгуулагчийн эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээний зардлын төлбөрийг холбогдох хууль хяналтын байгууллага хариуцан буруутай этгээдээр нөхөн төлүүлнэ” заалтын хэрэгжилтийг ханггуулж ажиллана.	ЭМДС-д төвлөрсөн орлогын дүн	670 хэрэгт байгууллагын хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалан оролцож, нотлох баримт, тайлбар хүсэлт хүргүүлсэн 385 албан бичгийг боловсруулсан байна.	Иргэний нэхэмжлэлээр эрүүгийн хэрэгт оролцсон байна.	ЭМДтХ-ийн 12 дугаар зүйлийн 12.1.1-т заасны дагуу гэмт хэрэг, зөрчлийн улмаас эрүүл мэнд нь хохирсон даатгуулагчийн эрүүл мэндийн тусlamж үйлчилгээний зардлын төлбөрийг гэм буруутай этгээдээр нөхөн төлүүлэхээр эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд иргэний нэхэмжлэгчээр оролцож 2025 оны хагас жилийн байдлаар 1999 иргэнээс 1,569,483,914 төгрөгийг ЭМДСанд нөхөн төлүүлсэн байна. Үр дүн: ЭМДСанд 1,569,483,914 төгрөгийг нөхөн төлүүлсэн байна.	2025.01.02 2025.05.25	100

Зорилт 3. “ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИЙН НИЙТЛЭГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛАХ” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД”

1.	Албан тушаалын тодорхойлолтын 4.13 Арга хэмжээ 3.1. Байгууллага, газар хэлтсүүдээс зохион байгуулж буй төлөвлөгөөт болон цаг үеийн ажил, удирдлагаас өгсөн албан ёсны шийдвэрийн дагуу багаар болон ганцаарчилсан ажил үргийг гүйцэтгэх	Өгөгдсөн үүрэг даалгаврын тоо	20 үүрэг даалгавар биелүүлсэн байна.	Тайлант хугацаанд өгөгдсөн үүрэг даалгаврын тоо	ЭМДЕГ-ын 2025 оны 05 дугаар шуурхай хурлаас өгсөн үүрэг даалгаврын дагуу Гадаадын иргэн, харьяалалгүй хүний регистртэй холбоотой үүсээд байгаа асуудлыг судлах, нэгдсэн мэдээлэл бэлтгэх, цаашид авах арга хэмжээг бусад нэгжтэй хамтран судалж, танилцуулах үүргийн хүрээнд Гадаадын иргэн, харьяалалгүй хүний регистртэй холбоотой үүсээд буй нөхцөл байдлыг арилгах чиглэлээр Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газарт мөн Эрүүл мэндийн даатгалын үндэсний	2025.01.02 2025.05.25	100
----	---	-------------------------------	--------------------------------------	---	---	--------------------------	-----

зөвлөлд хувийг Монгол Улсын Гадаад харилцааны яамны Консулын газарт тус тус албан бичиг хүргүүлсэн.

Хууль зүй, дотоод хэргийн яамаар ЭМДЕГ-ын даргын 2025 оны А/30 дугаар тушаалаар батлагдсан "Нэхэмжлэлийг хянах журам"-ыг захирагааны хэм, хэмжээний актаар бүртгүүлж ажилласан. -Байгууллагын үйл ажиллагааг цахимжуулах ажлын хүрээнд хууль, эрх зүйн орчны судалгаа хийж, удирдлагад танилцуулсан.

-МУ-ын Засгийн газрын хуралдааны цахим системд 2025 оны хагас жилийн байдлаар агентлагын үйл ажиллагаанд холбогдох Засгийн газрын тогтоол 7, тэмдэглэл 4, Ерөнхий сайдын захирамж гараагүй болно.

-ХАГГ-аас дотоод албан бичгээр тус газарт ирүүлсэн газар, хэлтсийн чиг үүргийн талаарх асуудлыг судлаж холбогдох албан тушаалтнаас тайлбар авч хариуг боловсруулан удирдлагад танилцуулсан.

Үр дүн: ЭМДЕГ-ын 1 шуурхай хурлаас 1, удирдлагаас өгсөн 5 үүрэг даалгавар авч, ЭМДЕГ-ын даргын тушаалаар батлагдсан 5 ажлын хэсэгт орж үүрэг даалгаврыг цаг тухайд нь биелүүлсэн байна.

2.	Арга хэмжээ 3.2. Тамгын газрын Эрх зүйн асуудал хариуцсан мэргэжилтнийг түр эзгүйд түүний албан үүргийг түр орлон гүйцэтгэж, үр дүнг танилцуулна.	Төрийн үйл ажиллагааны тасралтгүй, шуурхай байдал	295 лавлагаа авах тухай албан бичгийн хариуг хүргүүлж, 23 гэрээний эрх зүйн үндэслэлийг хянаж, бүртгэл хөтөлсөн байна.	Түр гүйцэтгэсэн хугацаанд хэрэгжүүлж ажиллана.	орлон хийж	Төрийн үйл ажиллагааны тасралтгүй, шуурхай байдлыг хангаж ажиллана.	2025.01.02 2025.05.25	-
----	--	---	--	--	------------	---	--------------------------	---

ХОЁР. МЭДЛЭГ, УР ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин					
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэл тийн хувь	
1	2	3	4	5	6	7		
1.	Арга хэмжээ 2.1 Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын 2025 оны сургалтын нэгдсэн төлөвлөгөөнд тусгагдсан болон хариуцсан үйл ажиллагааны чиглэлээр зохион байгуулагдсан сургалтад хамрагдана.	Зохион байгуулагдсан сургалтад бүрэн хамрагдсан байна.	14 хоног тутмын Лхагва гарagt Мэдээллийн цаг-12 удаа, ТАЗ-н долоо хоног бүрийн Пүрэв гарагийн 7:4:10 сургалт 22 удаа хамрагдсан байна	Зохион байгуулагдсан сургалтад хамрагдаж, мэдлэг дээшлүүлсэн байна.	Албан хаагчдад танин мэдэхүйн чиглэлээр ажил амьдралд ашиглагдахуйц мэдээллийг өгөх зорилгоор 14 хоног тутам зохион байгуулдаг 6 удаагийн "Мэдээллийн цаг"-т ZOOM болон танхимаар тогтмол оролцсон.	2025.01.02 2025.05.25	100	
2	Арга хэмжээ 2.2 Монгол бичгийн мэдлэгээ дээшлүүлсэн байна.	Сургалтад хамрагдсан байна.	-	Бие дааж сурсан	Монгол улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй "Монгол бичгийн үндэсний хөтөлбөр III"-ийн хүрээнд 2025 оноос эхлэн хос бичигтэн болох хуулийн хэрэгжилтийг хангах, монгол бичгийн хэрэглээ, орчинг нэмэгдүүлэх зорилгоор ЭМДЕГ-ын төв, орон нутаг дахь нийт албан хаагчдад зориулж "Монгол бичиг"-ийн	2025.01.02 2025.05.25	80	

					цахим хичээлийг телеграм группээр суралцаж байна.		
3	Арга хэмжээ 2.3 Удирдлагын академийн Ахлах түшмэлийн багц сургалтад хамрагдана.	Багц сургалтад хамрагдсан байна.	-	Сургалтад хамрагдаж гэрээ байгуулсан байна.	Ахлах түшмэлийн багц сургалтад хамрагдаж дууссан болно.	2025.01.02 2025.05.25	100
4	Арга хэмжээ 2.4 “Хуульч шиг сэтгэж сурах нь” хууль сэтгэлгээ нэмэгдүүлэх мэргэшүүлсэн сургалтад хамрагдана.	Сургалтад хамрагдсан байна.	-	Сургалтад хамрагдсан байна.	“Хуульч шиг сэтгэж сурах нь” хууль сэтгэлгээ нэмэгдүүлэх мэргэшүүлсэн сургалтанд хамрагдаж сертификат авсан болно.	2025.01.02 2025.05.25	100

ТАЙЛАН ГАРГАСАН:
ЭРХ ЗҮЙН АСУУДАЛ ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТЭН

(Д.ГАНТУЯА)

2025.05.28

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 дугаар тушаалын
6 дугаар хавсралт

**ЭРХ ЗҮЙН АСУУДАЛ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН
С.СУВД-ЭРДЭНИЙН 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлт ийн хувь
			1	2	3	4	5
Зорилт 1. Салбарын хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгоно.							
1.	Арга хэмжээ № 1.1 Эрүүл мэндийн даатгалын байгууллагын хууль эрх зүйн орчинд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, зөрчил, хийдлийг арилгана.	Тайлант хугацаанд хянасан тушаал, шийдвэрийн тоо.	2024 онд байгууллагын даргын - 108-н тушаалын хууль эрх зүйн үндэслэлд холбогдох хууль эрх зүйн хяналт хийсэн	Эрх зүйн үндэслэлийг хуульд нийцүүлэн хянсан байна.	Газрын даргын 2025 оны А/08 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсэгт ажиллаж Засгийн газрын 2016 оы 59 дүгээр тогтоолын тавдугаар хавсралтаар баталсан Хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ хийх аргачлал, зургаадугаар хавсралтаар баталсан Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлалын дагуу Эрүүл мэндийн даатгалын байгууллагын хуулийн орчин, хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийж, зөрчил, хийдэл, давхардлыг арилгах санал боловсруулахаар ажиллаж байна.	2025.01.02-05.28	100%

				<p>Хуулийн хэрэгжилтийн явц дахь ололтыг бататгах, хэрэгжилтийн байдалд бодит дүн шинжилгээ хийж, гарч буй хүндрэл, бэршээлтэй асуудал, эерэг, сөрөг нөлөөлийг илрүүлэхх, цаашид зохистой үр дүнтэй хэрэгжих, хэрэгжүүлэх боломжит хувилбарыг тодорхойлоход гол зорилгойтой болно.</p> <p>Тайлант хугацаанд байгууллагын үндсэн үйл ажиллагаатай холбоотой гаргаж буй тушаал, холбогдох бусад шийдвэрийн төслийн хууль, эрх зүйн үндэслэлийг судалж, хуульд нийцүүлэн хянаж, зөвлөгөө өгч ажилласан. Газар хэлтсүүдээс боловсруулсан байгууллагын үйл ажиллагаатай холбоотой тушаалын төсөлд хууль эрх зүйн талаас хяналт хийсэн бөгөөд өөрийн хариуцсан чиг үүргийн хэрээнд 5 тушаалын төсөл боловсруулан баталгаажуулсан байна</p> <p>Үр дүн: Байгууллагын даргын тушаалын хууль эрх зүйн үндэслэлд холбогдох хууль эрх зүйн хяналт хийсэн.</p>	
--	--	--	--	--	--

2.	Арга хэмжээ № 1.2 Байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдах гэрээний бүртгэл хөтлөх, шинээр болон шинэчлэн боловсруулах, санал, зөвлөмж өгөх, эрх зүйн үндэслэлийг хуульд нийцүүлэн хянах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.	105	209 гэрээ байгуулж ажилласан.	Шинээр болон шинэчлэн боловсруулж буй гэрээний эрх зүйн үндэслэлийг хуульд нийцүүлэн хянаж, бүртгэл хөтлөх үйл ажиллагааг хэрэгжүүлсэн байна. Нийт 84 гэрээнд эрх зүйн үндэслэлийг хуульд нийцүүлэн хянаж, санал зөвлөмж өгч хамtran ажиллаж, дугаарлан гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллаж байна. Салбар дундын уялдаа холбоог хангаж ажиллах ажлын хүрээнд Эм эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар, МУ-н нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа тусгай зөвшөөрөлтэй нийтийн эмийн сангийн мэдээллийг цуглуулах, бүртгэх, эмчийн бичсэн цахим жорын дагуу эм олгох, түүнд хяналт	Байгууллагын хэмжээнд 2025 оны хагас жилийн байдлаар: - Хамтран ажиллах гэрээ – 56 - Ажил гүйцэтгэх гэрээ - 23 - Худалдах, худалдан авах гэрээ – 1 - Хөлсөөр ажиллах гэрээ - 2 - Үл хөдлөх хөрөнгө худалдан борлуулах зуучлалын гэрээ – 1 - Ажлын байр түрээслэх гэрээ - 1 Нийт 84 гэрээнд эрх зүйн үндэслэлийг хуульд нийцүүлэн хянаж, санал зөвлөмж өгч хамtran ажиллаж, дугаарлан гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллаж байна. Салбар дундын уялдаа холбоог хангаж ажиллах ажлын хүрээнд Эм эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар, МУ-н нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа тусгай зөвшөөрөлтэй нийтийн эмийн сангийн мэдээллийг цуглуулах, бүртгэх, эмчийн бичсэн цахим жорын дагуу эм олгох, түүнд хяналт	2025.01.02-05.28	100%

				тавих зорилготой хамтран ажиллах гурван талт гэрээг хийж баталгаажуулан бүртгэсэн ажиллаж байна. Үр дүн: Байгуулсан гэрээтэй холбоотой асуудлаар маргаан гараагүй бөгөөд байгууллагын үйл ажиллагааны тасралтгүй байдлыг гэрээгээр дамжуулан ханггуулж ажилласан.		
3.	Арга хэмжээ №1.3 Захиргааны ерөнхий хуульд заасны дагуу сонсох ажиллагаа явуулах, тайлбар, нотлох баримт цуглуулах, дүгнэлт бичиж зохих шийдвэрийг гаргуулна.	Нийт сонсох ажиллагааны тоо.	8 сонсох ажиллагааг явуулсан.	Сонсох ажиллагааг хуулийн хүрээнд явуулж шийдвэрлэсэн байна.	Захиргааны ерөнхий хуульд заасны дагуу 8 албан хаагчид сонсох ажиллагааг явуулж, тайлбар, нотлох баримт цуглуулах ажиллагааг холбогдох хууль журмын хүрээнд зохион байгуулж удирдлагад танилцуулан Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Байгууллагын хөдөлмөрийн дотоод журам зэргийг үндэслэн 1 албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулж хариуцлага хүлээлгэсэн. Байгууллагын Ёс зүйн дэд хороонд ирсэн гомдолыг хүлээн авч шийдвэрлэж Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Ёс зүйн дэд хорооны ажиллах журмын дагуу дүгнэлт үйлдэж томилох эрх бүхий албан тушаалтанд танилцуулсан болно.	2025.01.02-05.28 100%

				Үр дүн: Сахилгын шийтгэл ноогдуулж, хариуцлага тооцох нь нийт албан хаагчдын ажлын хариуцлагыг сайжруулах, хариуцлагыг нэмэгдүүлж байна.		
4	Арга хэмжээ № 1.4 Шүүх, хууль хяналтын байгууллагад байгууллага, албан тушаалтныг төлөөлөх, мэдээлэл, нотлох баримт бүрдүүлэх, тайлбар гаргах, хамтран ажиллах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.	Тайлант хугацаанд хамтран ажилласан тохиолдлын тоо.	230 хэрэгт төлөөлөн оролцсон.	Шүүх, хууль хяналтын байгууллагад байгууллага, албан тушаалтныг төлөөлөн оролцож, хамтран ажиллах үйл ажиллагааг хэрэгжүүлсэн байна.	Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1-дэх заалтыг хангаж ажиллах, ажлыг үр дүнтэй эрчимжүүлэх чиглэлээр НПГазар, ЦЕГ-н Мөрдөн байцаах албаны холбогдох албан тушаалтнуудтай 3 удаагийн уулзалт зохион байгуулж холбогдох мэдээллээ солилцон хамтраж ажиллаж, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний зардлыг нөхөн төлүүлэх ажилд нийслэлийн болон орон нутгийн Цагдаагийн газарт шалгагдаж байгаа эрүүгийн хэрэгт манай байгууллагыг иргэний нэхэмжлэгчээр томилж, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд тайлбар мэдүүлэг өгөх үйл ажиллагааг цахимжуулах талаар ЦЕГ, Нийслэлийн Прокурорын багууллагатай	2025.01.02-05.28 100%

5	Арга хэмжээ № 1.5 Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын төв, орон нутгийн ажилтнуудыг хууль зүйн зөвлөгөө, мэдээллээр	Хууль зүйн мэдээлэл, зөвлөгөөний тоо.	Тайлант хугацаанд 25 албан хаагчдад хууль эрх	Хууль зүйн мэдээлэл, зөвлөгөө, мэргэжил, арга зүйн удирдлагаар	хамтран ажиллаж, албан ёсны hohirol@emd.gov.mn хаягаар баримт бичгээ солилцон тоон гарын үсгээр баталгаажуулан хүргүүлж ажиллаж байна. 2025 оны 04 дүгээр сарын 23-ны өдрөөс хойш 28-н эрүүгийн хэрэгт цахим хэлбэрээр мэдүүлэг гаргаж нэхэмжлэл үүсгэж ажиллаа. 2025 оны 01 дүгээр сарын 02-с 04 дүгээр сарын 22-ныг хүртлэх хугацаанд цаасан хэлбэрээр 115 хэрэгт Иргэний нэхэмжлэгчээр оролцож мэдүүлэг гагасан байна. Үр дүн: Мэдүүлэг өгөх, авах ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлснээр Эрүүл мэндийн даатгалын санг нөхөн бүрдүүлэх ажиллагаа эрчимжиж албан хаагчдын ажил хялбар болсон үр дүнтэй ажил болсон.	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын төв, орон нутгийн ажилтнуудад хууль эрх зүйн мэдээлэл, зөвлөгөө, мэргэжил арга зүйн удирдлагаар хангах,	2025.01.02-05.28	100%

	хангаж, эрх зүйн туслалцаа үзүүлнэ.	зүйн мэдээлэл, зөвлөгөөгөө өгч ажилласан.	хангаж, эрх зүйн туслалцаа үзүүлж ажилласан байна.	эрх зүйн туслалцааг өдөр тутам үзүүлж ажиллаж байна. Байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдаж буй Иргэний хуулиар зохицуулсан аливаа гэрээг хууль эрх зүйн хүрээнд хэрхэн боловсруулах, гэрээний бүтэц, гэрээний талуудын эрх, ашиг сонирхлыг адил тэгш хангах, гэрээний стандарт болон гэрээ байгуулахад анхаарах зүйлсийн талаар, мөн Иргэний нэхэмжлэгчээр байгууллага төлөөлөлн ажиллах, мэдүүлэг цахим хэлбэрт шилжсэнтэй холбоотой заавар зөвлөмжийг өгч ажиллаж байна. Үр дүн: Албан хаагчдын ажил хялбар болсон.		
6	Арга хэмжээ № 1.6 Зөрчил шалган шийдвэрлэх болон Төрийн хяналт шалгалтын үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангаж, холбогдох байгууллагатай хамтран ажиллана.	Сургалт, арга зүйгээр хангасан тохиолдлын too.	-	Хуулийн хэрэгжилт хангагдсан байна. 2025 он гарснаар Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг зохион байгуулаагүй бөгөөд гомдол хүлээн аваагүй байна. Нийслэлийн Прокурорын газрын Хяналтын прокурортой хамтран зөрчил шалган шийдвэрлэх эрх бүхий албан хаагчдад “Зөрчлийн хэрэг бүртгэлтийн ажиллагаа явуулахад анхаарах	2025.01.02-05.28	100%

				<p>асуудал” сэдэвт сургалтыг зохион байгууллаа.</p> <p>МУ-н Прокурорын газраас зохион байгуулсан “Зөрчлийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан”-ийн хэрэглэгч нарт зориулсан сургалтад байгууллагын ЭБАТушаалтнуудыг бүрэн хамруулж мэдээллээр хангаж ажлын зохион байгуулсан.</p> <p>Үр дүн: ЭБАТушаалтнууд Зөрчлийн хэрэг бүртгэлтийн ажиллагаа явуулах, гомдол мэдээлэл хүлээн авч хянах шалгах мэдлэг мэдээлэлтэй болсон.</p>	
--	--	--	--	--	--

Зорилт 2. Эрүүл мэндийн даатгалын хамралт, орлого, тусlamж, үйлчилгээний тоо хэмжээ нэмэгдүүлнэ.

1.	<p>Арга хэмжээ № 2.1 Капитал банк ХХК-ийн эрх хүлээн авагчаас шилжиж ирсэн үл хөдлөх хөрөнгийг худалдан борлуулах, эдийн засгийн эргэлтэд оруулах, шилжүүлэх ажлыг зохион байгуулж, эрх зүйн баримт бичгийг боловсруулна.</p>	<p>ЭМДС-д төвлөрсөн орлогын дүн.</p>	<p>ЭМД-ын санд 6.1 тэрбум төгрөгийн орлого төвлөрсөн.</p>	<p>Капитал банк ХХК-ийн эрх хүлээн авагчаас шилжиж ирсэн үл хөдлөх хөрөнгийг худалдан борлуулах, ЭМД-ын санд орлогыг төвлөрүүлсэн байна.</p>	<p>“Капитал банк ХХК-ийн эрх хүлээн авагчаас ЭМДСангийн өр төлбөрт хүлээн авсан хөрөнгүүдийг худалдан борлуулах ажлыг эрчимжүүлэх санийн хөрөнгийг бүрдүүлэх ажлыг зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсгийг газрын даргын 2025 оны А/06 дугаар тушаалаар байгуулсан. Тус ажлын хэсэг нь ажиллах ажлын төлөвлөгөө гаргаж төлөвлөгөөний дагуу ажиллаж тайлан мэдээг гарган удирдлагад танилцуулсан.</p>	2025.01.02-05.28	100%
----	--	--------------------------------------	---	--	---	------------------	------

					Үр дүн: ЭМД сангийн мөнгөн хөрөнгийг нөхөн бүрдүүлэх ажил эрчимжиж байна.		
2.	Арга хэмжээ № 2.2 Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийн 12.1.1 дэх заалтад “гэмт хэрэг, зөрчлийн улмаас эрүүл мэнд нь хохирсон даатгуулагчийн эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээний зардлын төлбөрийг холбогдох хууль хяналтын байгууллага хариуцан буруутай этгээдээр нөхөн төлүүлнэ” заалтын хэрэгжилтийг хангуйж ажиллана.	ЭМДС-д төвлөрсөн орлогын дүн.	ЭМД-ын санд 1.3 тэрбум төгрөгийн орлого төвлөрсөн.	Хуулийн хэрэгжилтийг хангуйж ЭМД-ын санд орлогыг төвлөрүүлсэн байна.	Гэмт хэргийн улмаас эрүүл мэнд нь хохирсон даатгуулагчийн эрүүл мэндийн даатгалын сангаас авсан тусlamж үйлчилгээний зардлыг гэм буруутай этгээдээр нөхөн төлүүлэх үйл ажиллагааг холбогдох хууль хяналтын байгууллагатай хамтран ажиллаж ЭМДСангийн мөнгөн хөрөнгийг нөхөн төлүүлж байна. Үр дүн: ЭМД сангийн мөнгөн хөрөнгийг нөхөн бүрдүүлж байна.	2025.01.02-05.28	100%

Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт

Д/д	Үүрэг даалгавар (арга хэмжээ)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
-----	----------------------------------	------------------	--------------	--------------	----------------------------	--------------------------	-----------------

Зорилт 3. Дотоод зохион байгуулалтын ажилд оролцох, удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг биелүүлэх, хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх.

1.	Арга хэмжээ № 3.1 Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтаар үүсэж хөтлөгдсөн хэргийг батлагдсан хуваарийн дагуу байгууллагын архивт шилжүүлнэ.	Архивын нэгж бүрдүүлэлтийн тоо (боть).	2024 онд нийт 3 боть архивын нэгж үүссэн.	Үүссэн архивын нэгжийг байгууллагын архивт шилжүүлсэн байна.	Байгууллагын Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтаар үүсэж хөтлөгдсөн 2024 оны гэрээг батлагдсан хуваарийн дагуу байгууллагын гэрээний 4 боть тендерийн 18 боть	2025.01.02-05.28	100%
----	--	--	---	--	---	------------------	------

					материалыг байгууллагын архивд шилжүүлж хүлээлтгэн өгсөн.		
2.	<p>Арга хэмжээ № 3.2</p> <p>Даргын зөвлөлийн болон шуурхай хуралдаан, цаг үеийн шинжтэй удирдлагаас өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг хангаж, биелэлтийг хугацаанд нь үнэн зөвөөр тайлagnana.</p>	<p>Өгөгдсөн үүрэг даалгаврын тоо.</p>	<p>Тухай бүр үүрэг даалгаврыг гүйцэтгэсэн.</p>	<p>Тайлант хугацаанд өгөгдсөн үүрэг даалгаврыг хугацаанд нь хэрэгжүүлсэн байна.</p>	<p>Газрын даргын зөвлөлийн болон шуурхай хуралдаанаас өгөгдсөн болон цаг үеийн шинжтэй удирдлагаас өгөгдсөн үүрэг даалгавруудыг цаг хугацаанд нь хийж гүйцэтгэсэн. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Улсын байцаагчийн эрхтэй мэргэжилтнүүдээс хийж хэрэгжүүлсэх ажлын тайлан, акт албан шаардлага, зөвлөмжийн тоог, нотлох баримттай гаргуулж, газар дээрх хяналт шалгалтын илэрсэн зөрчил дээр тайлбар авч танилцуулах, хяналт тавин ажиллах. 	2025.01.02-05.28	100%

					<ul style="list-style-type: none"> - Нийслэлийн прокурорын газарт албан бичиг хүргүүлж, аль зүйл заалтаас болж шүүхээс буцаагдаж байгаа тайлбар авч танилцуулах - Ёс зүйн хорооны ажлын хэсгийн бүрэлдэхүүн ийг шинэчлэн батлуулах - Байгууллагын үйл ажиллагаан д ашиглагдах бичиг хэргийн зардалд тоо хэмжээг өөрчилж дахин зарлах зэрэг үүрэг даалгаварыг авч тайлагнаж ажилласан. 	
--	--	--	--	--	--	--

					Үр дүн: Удирдлагыг мэдээллээр хангаж, үүрэг даалгаврын биелэлтийн хэрэгжилт хангагдана.		
3.	Арга хэмжээ № 3.3 Эрх зүйн асуудал хариуцсан мэргэжилтний түр эзгүйд түүний албан үүргийг түр орлон гүйцэтгэж, үр дүнг хариуцана.	Түр орлон гүйцэтгэх хугацаанд хийж хэрэгжүүлсэ н ажил, үйлчилгээнүү тоо.	Ээлжийн амралттай болон албан ёсны чөлөөтэй үед ажлыг орлон гүйцэтгэсэн.	Төрийн үйл ажиллагааны тасралтгүй, шуурхай байдал хангагдана.	Д.Гантуяа мэргэжилтний түр эзгүйд түүний албан үүргийг түр орлон гүйцэтгэх хугацаандаа Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийн 12.1.1 дэх заалтад “гэмт хэрэг, зөрчлийн улмаас эрүүл мэнд нь хохирсон даатгууллагчийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардлын төлбөрийг холбогдох хууль хяналтын байгууллага хариуцан буруутай этгээдээр нөхөн төлүүлнэ” гэж заасны дагуу хууль хяналтын байгууллагад хянагдаж байгаа эрүүгийн хэрэгт Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх	2025.01.02-05.28	100%

					тухай хуулийн 8.5 дугаар зүйлийн 8.5.1 дэх заалтад заасны дагуу иргэний нэхэмжлэгчээр оролцож ажиллаа. Үр дүн: Төрийн ажил тасралтгүй явагдаж байна.	
4.	Арга хэмжээ № 3.4 Цагийн үеийн шинжктэй ажил үүргийг гүйцэтгэж ажиллана.	Хариуцсан үйл ажиллагааны чиглэлээр хийж хэрэгжүүлсэн ажлын тоо.	Өдөр тутмын үйл ажиллагаанд хариуцсан асуудлаар үнэн зөв мэдээ, мэдээлэл, бэлтгэх, судалгаа, тайлан, төлөвлөгөө, биелэлт гаргаж ажилласан.	Хариуцсан үйл ажиллагааны чиглэлээр үр дүнтэй ажилласан байна.	Өөрийн хариуцсан ажил үүрэг, асуудлаар мэдээ тайлан үнэн зөв цаг хугацаанд нь гаргаж, удирдлагаас өгсөн үүрэг чиглэлийн дагуу холбогдох хууль дүрэм журмын хүрээнд үр дүнтэй ажиллаж, албан тушаалын тодорхойлолтоор хүлээсэн чиг үүргээ бүрэн хэрэгжүүлж, архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль тогтоомж, стандартыг чанд мөрдөж, мэдээллийн ил тод байдлыг ханган ажиллаж байна. Үр дүн: Улирдлагаас өгсөн үүрэг даалгавар болон хариуцсан үйл ажиллагааны	2025.01.02-05.28 70%

					чиглэлээр ур дүнтэй ажилласан.	
--	--	--	--	--	--------------------------------------	--

Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биел элти йн хувь
1	2	3	4	5	6	7	
1.	Арга хэмжээ 1. Төрийн албан хаагчийн мэдлэг чадвараа дээшлүүлэх боломжит сургалтуудад хамрагдана.	Сургалтын тоо.	Сургалтын хөтөлбөр батлагдсан.	Зохион байгуулагдсан сургалтад бүрэн хамрагдсан байна.	Tөрийн албан хаагчийн мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх үүднээс Улаанбаатар Эрдэм Их сургуулийн “Төрийн захиргааны менежмент”-ийн магистрт суралцан төгссөн. Хууль зүй дотоод хэргийн яамнаас зохион байгуулсан 2 удаагийн сургалт хэлэлцүүлэг, Хууль зүйн хүрээлэнгээс зохион байгуулсан Захиргааны хэм хэмжээний актыг legalinfo.mn сайтад хэрхэн бүртгүүлэх тухай сургалтад хамрагдаж мэдлэг мэдээлэлтэй болсон. Үр дүн: Төрийн мэдлэг, ур чадвараа нэмсэн.	2025.01.02-05.28	100%
2.	Арга хэмжээ 2. Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын 2025 оны сургалтын нэгдсэн төлөвлөгөөнд тусгагдсан болон хариуцсан үйл ажиллагааны чиглэлээр	Сургалтын тоо.	Батлагдсан сургалтын хөтөлбөр болон хариуцсан үйл	Зохион байгуулагдсан сургалтад бүрэн	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар болон орон нутаг дахь Эрүүл мэндийн даатгалын хэлтсийн	2025.01.02-05.28	80%

зохион байгуулагдсан сургалтад хамрагдана.	ажиллгааны чиглэлээр сургалтад хамрагдсан.	хамрагдсан байна.	албан хаагчдыг чадавхжуулах сургалтууд, Албан хаагчдад танин мэдэхүйн шинэ мэдээлэл өгөх, солилцох зорилгоор ЭМДЕГ-ын "Мэдээллийн цаг"-ийг сургалтуудад хамрагдаж мэдлэг мэдээлэлтэй болсон. Үр дүн: Төрийн албан хаагчийн мэдлэгээ дээшлүүлсэн.	
--	--	-------------------	---	--

ТАЙЛАН ГАРГАСАН:

Эрх зүйн асуудал хариуцсан
мэргэжилтэн

..... / С.Сувд-Эрдэнэ /


2025.01.02-05.28

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 дугаар тушаалын
5 дугаар хавсралт

ЭРХ ЗҮЙН АСУУДАЛ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН
С.СУВД-ЭРДЭНИЙН 2025 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
НЭМЭЛТ ҮҮРЭГ ДААЛГАВАРЫН ТАЙЛАН

Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт

Д/д	Үүрэг даалгавар (арга хэмжээ)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэ лтийн хувь
1	Байгууллагын 2025 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан зарим үйл ажиллагааг зохион байгуулж ажиллах.	Зохион байгуулсан ажлын тоо 2	Цаг үеийн ажил үүргийг тухай бүр нь гүйцэтгэж ажилласан.	Хариуцсан үйл ажиллагааны чиглэлээр үр дүнтэй ажилласан байна.	Байгууллагын 2025 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг tender.gov.mn сайтад байршуулсан. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн байгууллагын албан хэрэгцээний цэрэвлэгээ болон бичиг хэргийн материал худалдан авах ажиллагааг зохион байгуулж цэвэрлэгээний материал материал нийлүүлэгчийг сонгон шалгаруулж гэрээ байгуулсан болно. Бичиг хэргийн материал худалдан авах ажилгааны тендерт оролцогчоос гомдол гарсан тул Сангийн Яамны шийдвэрийг хүлээж байна.	2025.01.02-05.28	100%

ШШГГАЗАР, ЭМДЕГ-Н
хамтын ажиллагааны
санамж бичиг зурах ажлыг
зохион байгуулсан.

Тус санамж бичгийг
байгуулснаар Эрүүл
мэндийн даатгалын тухай
хуулийн 12.1 дэх заалт,
Шүүхийн шийдвэр
гүйцэтгэх тухай хуулийн
263.1.1 дэх заалтыг тус тус
үндэслэн Эрүүл мэндийн
даатгалын байгууллагын
төлбөрийн шаардлага
бүхий шүүхийн шийдвэр
гүйцэтгэх ажиллагааг
хуулийн дагуу шуурхай
зохион байгуулж ажиллах
зорилготой болно.

Үр дүн: Байгууллагын
худалдан авах ажиллагаа
хууль журмын хүрээнд
явандаж байна.

ТАЙЛАН ГАРГАСАН:

Эрх зүйн асуудал хариуцсан
мэргэжилтэн

..... / С.Сувд-Эрдэнэ /

2025.01.02-05.28.